

Зөвлөмж

2014.11.10

Сэлэнгэ аймгийн Баянгол суманд гахайн сонгомол мялзан өвчин гарсантай холбогдуулан мялзан өвчний талаар товч ойлголт болон анхаарвал зохих зарим зүйлүүдийг зөвлөмж болгон хүргүүлж байна.

Гахайн мялзан нь хавьталын замаар халдварладаг өндөр халуурал, цус төлжүүлэх эрхтний гэмтэл, уушиг, бүдүүн гэдэсний нэвчдэст үрэвслээр илэрдэг гоц халдварт өвчин бөгөөд нас хүйс харгалзахгүйгээр бүх гахайг өвлүүлдэг онц аюултай өвчин юм.

Халдвар тархах зам. Өвчтэй юм уу, өвчилж эдгэрсэн гахай халдварын эх уурхай болдог бөгөөд тэдгээрийн баас, шээс, шүүрдэс, сүү, үртэй хамт ялгаран гарсан вирусээр бохирлогдсон зогсоол, тэжээл, ус, хэвтэр бууц, тоног хэрэгсэл, хүний хувцас, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, түүхий эдээр дамжин халдвар тархана. Өвчилж эдгэрсэн гахай 3-10 сарын турш тээгч болохоос гадна өвчилж үхсэн гахайн сэг зэмд хүрсэн ан, амьтан, мэрэгч, шавьж хүртэл механикаар халдвар тараана. Тийм учраас өвчилсөн гахайг **эмчилгээ хийдэггүй, шууд нядлаж устгана.** Иймд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ доорхи зөвлөмжүүдийг ахнаарч ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1. Гахайтай айл өрх, аж ахуй нэгжийн судалгааг үндэслэн гахайн тоо, толгойг нарийвчлан гаргах
2. Нийт гахайнаас мялзангийн вакцинд хамрагдсан хэд, хамрагдаагүй гахайн тоо толгойг салгаж гаргах
3. Вакцин хийсэнээс хойш шинээр нэмж гарсан торой, бусад аймаг сумаас шилжиж ирсэн гахайн тоо, толгойг гаргах
4. Гахайн мялзан өвчний талаар болон түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл, ухуулгын ажлыг мал бүхий иргэд аж ахуй нэгж байгууллагад хүргэх, хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр сурталчлах
5. Халдварт өвчнөөс сэргийлэх ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалалын хувцасны зохих нөөцийг буй болгох
6. Сүүлийн нэг сарын хугацаанд өөр аймаг сумын нутаг дэвсгэрээс шилжиж ирсэн мал, амьтаны шилжилт хөдөлгөөн байгаа эсэхт тандалт хийх, иргэдээс энэ талаар мэдээлэл цуглуулах
7. Тодорхой бус шалтгаанаар үхэж хорогдсон мал, тэжээвэр гахай байгаа эсэхэд тандалт хийх, мэдээлэл цуглуулах
8. Голомт бүхий бүс нутгаас мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, мах, сүү, амьд мал, амьтныг нэг сарын турш оруулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах
9. Голомт бүхий бүс нутгаас орж гарах гол замуудад хяналтын байнгын пост ажиллуулах
10. Вакцинд хамрагдаагүй гахайг нэмж тарилганд хамруулах ажлыг зохион байгуулах, шаардлагатай байгаа вакцины захиалгыг яаралтай ирүүлэх

Зөвлөмж боловсруулсан:

Мал эмнэлгийн хэлтсийн дарга

Х.Хавсамет